

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 18-ны өдөр

Дугаар

БА-079/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 32 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 2 блок 640 (зургаан зуун дөч) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 17-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/05/05 огноо, 0012673 дугаар, БАЗГ2023/203, 2023/09/28 огноо, 0013757 дугаар, БАЗГ2023/728, 2024/07/23 огноо, 0000605 дугаар, БА32024/0300, 2024/10/08 огноо, 0001056 дугаар, БА32024/0658,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ЭК-85/2022-31

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилгын "Б" блок 5 давхар, 11-324249 холбоо барих утас,

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Дарцагт ноёд групп ХХК оноосон нэр, 9011539044 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5945607 регистрийн дугаар, БУ11-136/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот Баянгол дүүрэг 13 дугаар хороо, 3 дугаар хороолол хасбаатар, 20, 7 тоот, 70139099 холбоо барих утас,

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эрхэс констракшн ХХК оноосон нэр, 9011444120 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5772621 регистрийн дугаар, ЗТ11-222/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 5 дугаар хороо, 10-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, энэрэл-2, 10 тоот, 99071547 холбоо барих утас,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургууль оноосон нэр, 9069001307 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9088849 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, 11-361027 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 2 блок 640 (зургаан зуун дөч) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯЛГАЛТ ШАЛГАЛТ
ГАЗАР
Барилга байгууламжийг а
оруулах комис

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 8 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 2 блок 640 (зургаан зуун дөч) суудал бүхий хүчин чадалтай сургуулийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 32 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ-ийн захиалгатай, зорьтой 3 давхар, 2 блок
640 суудалтай сургуулийн барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 32 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 3 ДАВХАР 2 БЛОК, 640
ХҮҮХДИЙН СУУДАЛТАЙ СУРГУУЛИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 32 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 3 давхар 2 блок, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхарт 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:00 цагт дуусав.



Хуралд:

- | | |
|--|---------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлтсийн дарга | Б.Ганзориг |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Барилга байгууламжийн төвийн ахлах инженер | Э.Ундрахцогт |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер | Б.Цэрэннадмид |
| 7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологи удирдлагын төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | Э.Уранчимэг |
| 8. Ус сувгийн удирдах газрын шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Ө.Шинэцэцэг |
| 9. Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төсөл хяналтын байцаагч, ахмад | Б.Дөл-Эрдэнэ |
| 10. Үндэсний Төв архив, зураг төслийн баримтын архивч | Н.Өлзийжаргал |
| 11. Барилгын хөгжлийн төв, Барилгын материалын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн | Б.Жаргал |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Б.Ганзориг |
| 13. Нийслэлийн боловсролын газрын | |

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
14. Эрхэс констракшн ХХК-ийн архитектор
15. Дарцагт ноёд групп ХХК-ийн захирал

Д.Ирмүүнзаяа
В.Сувд-Эрдэнэ
Д.Ганзориг

ХЯНА
Барилга ба

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 32 дүгээр хороо, Боловсролын ерөнхий газрын захиалгатай, зорьтой 3 давхар 2 блок, 640 суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Н.Ёндонсамбуу:**

- Лабораторийн шинжилгээ өгөх
- Урлаг заалны шалыг засаж янзлах
- Хагарсан цонхыг засаж янзлах
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот ирүүлэх
- Ус зайлуулах хоолой бүрэн дуусгах
- Ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна ажлыг хийж гүйцээх
- Агааржуулалтын систем гүйцээж хийх
- Зурагт тусгагдсаны дагуу цонхонд сараалжин хамгаалалт хийх /доод давхар/
- Барилгын баруун хэсгээр хүн хүүхэд зорчих эсэх /хамгаалалт хашлага хийх/
- Шилэн хийцлэлд гарал үүслийн гэрчилгээ үзүүлэх, өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- ГДХ-1 –ийг цэвэрлэж фото зургаар баталгаажуулах
- Узелийн өрөөний моторын дуу чимээг стандартын түвшинд бариулж хэмжилтийн дүнг шалгуулах
- Хоолны газар, спорт, урлаг заалны агааржуулалтын угсралтыг бүрэн дуусгаж ажиллагааг хэвийн болгох, дуу чимээг хэмжүүлж хэмжилтийн дүнг шалгуулах, баталгаа албан тоот ирүүлэх
- 00-ийн өрөөний агааржуулалтын системд зохиогч тайлбар ирүүлэх /решеткатай холбоотой/
- Халаах хэрэгслүүд дээр термостат вистель сольж дахин суурилуулах
- Дээвэр дээрх агааржуулалтын системийн шахтнаас бохирын хоолойг өндөрлөх

- Гадна дулаан шугам, агааржуулалтын системийн угсралт, дотор халаалт, узель угсралтын ил далд акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Барилга байгууламжийн төвийн ахлах инженер **Э.Ундрахцогт**:

- Гадна дулааны худаг цэвэрлэх. Худаг доторх огтолгооны хаалтууд халаалт хаагдсаны дараа сольж тавьж баталгаа албан бичиг ирүүлэх
- Узелийн эргэлтийн насос маш дуу ихтэй байгаа тул сольж эсвэл засварлаж дууг хэвийн болгож шалгуулах
- Температур тохируулах автоматик температурын доткинийг холилтын цэгийн дараа суурилуулах
- Холигч насосны узельд батлагдсан зургийн дагуу балансын хаалт тавих
- Спорт заалны босоо душнүүдэд хашилт хамгаалалт хийх
- Дотор систем тохируулга хийж халахгүй байгаа халаах хэрэгслүүдийг халаах
- Холигч насосны узелийн цахилгааны самбарын үндсэн тэжээл холбох

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ, Техник хяналтын хэсгийн ахлах инженер **Б.Цэрэннадмид**:

- Гадна цахилгааны дэд өртөөний улсын комиссын дүгнэлт, залгах зөвшөөрөл шалгуулах
- Үндсэн тэжээлийг холбож түр тэжээлийн самбар кабелийг хурааж цэгцлэх
- Ерөнхий шитний өрөөнд хаяг, плакат хийх
- ЕОС, ХС-уудад хаяг бичиглэл, схем заавар байрлуулах
- Оролтын кабелиудад хаяг, бирк хийх
- Гадна цахилгааны 0,4 кв-ын ЦДКШ -ийн батлагдсан ажлын зураг, мэдээллийн системд бүртгүүлсэн акт ил далд ажлын акт шалгуулах
- ЕОС -ийн хүрээ газардуулга болон аянга буултын газардуулга хэмжүүлсэн протокол шалгуулах
- Аянга хүлээн авах торыг ажлын зургийн дагуу гүйцээж дээврийн металл хийцүүдийг холбож фото актаар шалгуулах
- Техникийн нөхцөлийн 4.13 -н заалтад тайлбар албан бичиг ирүүлэх /авторын дүгнэлт/

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологи удирдлагын төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Э.Уранчимэг**:

- Шинээр хийгдсэн худагт шат, консол хийх фото зургаар баталгаажуулах
- Гаднаас орж ирж байгаа кабель татах сувагчлалын хоолойг битүүлсэн байна. Хаалтыг нурааж кабель татах боломжтой болгох фото зургаар баталгаажуулах

- Телефон утасны 10х2 хос байгаа кабелийг раканд цэнэглэж оруулж өгөх /холбооны өрөөний/ Фото зургаар баталгаажуулах
- Камерын телевизэд байгаа зарлан мэдээлэх мик, ракийг хананд бэхлэх хамгаалалтын тавиурт байрлуулах
- Урлаг заалны рамыг хамгаалалтын тавиурт суурилуулах
- Спорт заалны зарлан мэдээлэх системийн өсгөгчийг бөмбөгт цохигдохооргүй хамгаалалт хийж өгөх фото зургаар баталгаажуулах
- Хурлын өрөө, урлаг заал, багш нарын өрөөний шалны розеткуудыг хийж өгөх Фото зургаар баталгаажуулах
- Давхрын самбаруудын кабелиудыг хаягжуулах Фото зургаар баталгаажуулах
- ДХ-ны актыг нөхөж үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Ө.Шинэцэцэг:**

- УСУГ-аас олгосон 713/22 тоот техникийн нөхцөл, ОСНААУГ-ын 122/2022 тоот техникийн тодруулгад гадна ЦУШ-ыг УДДТ-110-2 ДХ-2 хүртэлх хэсэгт өргөтгөх гэсэн ажлыг хийгдээгүй тул татгалзаж байна
- УСУГ-ын 713/22 тоот техникийн нөхцөлийн хугацаа дууссаныг яаралтай сунгуулах
- Гүйцэтгэлийн зураг, акт тус бүр нэг хувийг УСУГ-т өгөх
- Усны нөөцийн савыг гүйцэд угсрах, шатыг хөдөлгөөнгүй хийх, температуур мэдрэгч суурилуулах
- Усны нөөцийн савыг стандартын дагуу ариутгал хийлгэх
- Усны тоолуурыг стандартын дагуу зөв хэмд суурилуулах, тойрох шугамыг ОСНААУГ-т мэргэжлийн талаас нэмэлт зөвлөгөө авах
- Бохир усны худагт дулаалгын таг хийх
- Бохир усны худгийн 1 дүгээр худгийн уналтын шугамыг стандартын дагуу отводоор унагах. Ажлын талбайг стандартын дагуу угсрах
- Усны шинжилгээ өгөх
- Хөрс борооны усыг бохирын шугамд нийлүүлэхгүй байх албан тоот өгөх
- Гадна цэвэр бохир усны актуудыг хангагч байгууллагаар хянуулж батлуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч **Б.Дөл-Эрдэнэ:**

- Галын дохиоллын систем, утаа мэдрэгчийн тагнууд салгаж авах
- Галын крантны хоолой хошууны хомут солих, ус тавьж туршин шалгасан акт Фото зургийг нөхөж үзүүлэх
- Дээвэрт гарах шатанд хамгаалалтын төмөр бэхэлж гагнах
- Гал унтраах автомат систем, спринклерийг туршин шалгасан акт фото зураг нөхөж үзүүлэх, шугам хоолойг өнгөөр ялгаж будах
- Барилгын гадна дулаалга ил далд ажлын акт, фото зургийг нөхөж үзүүлэх

- Өөрчлөлт оруулсан хийц бүтээцэд Захиалагч, гүйцэтгэгч, зургийн автор албан бичиг, дүгнэлт гаргаж өгөх
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж, гал унтраагуур байрлуулах
- Аврах зам гарцын тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэх
- Спорт заалны дээврийн сэндвичийн завсар зайг битүүлэх
- Агааржуулалт шугам хоолойг бүрэн гүйцэд угсарч хэвийн ажиллагаанд оруулах
- Гал унтраах автомашины орц гарц төлөвлөх
- Ус зайлуулах суваг шуудуу хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архив, зураг төслийн баримтын архивч **Н.Өлзийжаргал:**

- Хувийн хэрэгт нийтлэг жагсаалтын дагуу баримтыг бүрэн бүрдүүлэх
- Барилгад хэрэглэсэн материалын гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг бүрэн бүрдүүлэх
- Баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёог үйлдэх
- Ажлын зураг болон холбогдох баримтын эх хувийг архивд хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **Б.Жаргал:**

- Барилгын тухай хуулийн дагуу норм нормативын санд төлбөр төлөх
- Гадна борооны усны хаялга хаялбарт төгсгөл хийх /ф=150мм байна/
- Гал тогоонд тос баригч хийх
- Шатны төгсгөл нэг талд бариул хийх
- Шатны хашлагад хөвөө чулуу хийх
- Шаланд розетка, сүлжээний залгуур хийх
- Багана, хаалганы амалгаа буланг засварлах
- Дулааны секцийг хөндий хамгаалалт хийх
- Барилгын материалуудын гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээ үзүүлэх
- В1 давхрын өрөөнүүдэд салхивчийн систем хийх
- Урлаг заалны шалны бүтээцийг шалгуулах, хулдаас хөндийрсөн
- Хаалганы амлагаа хүрээг засварлах
- Анги танхимд үүссэн хананы хагарлыг засварлах
- Спорт заалны шал засварлах, сэндвич хавтанг бүрэн сольж засварлах
- Металл рамыг зориулалтын дагуу угсрах /хөндлөн татанги боогдоогүй/
- Үүдний металл рамыг зориулалтын дагуу хийх
- Шатны бариуланд бэхэлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тавцанг бэхлэх
- Парпедыг зураг төслийн дагуу хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага Б.Ганзориг:

- Гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх. Үүнд: Явган хүний зам авто замын ялгарал гаргах, авто зам, авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний зогсоолыг төлөвлөж хийж гүйцэтгэх, явган хүний зам дээр чиглүүлэгч замыг зориулалтын дагуу суурилуулах, шатны гадаргууг жигд болгох
- Орц хэсгийн налуу 2 талд бариул хийх, бүх шатны 2 талд бариул хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний ариун цэврийн өрөөг зориулалтын дагуу тоноглох
- Шатны дээр суурилуулсан өргөгч тавцанг хэвийн ажиллагаанд оруулж шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Нийслэлийн Боловсролын газрын Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн **Д.Ирмүүнзаяа**:

- Дотор засал сайжруулах хана, хаалга, плитаны шоов, шалны түвшнийг нэг болгох, 3 давхар коридор өнгө өөрчлөх
- Гал тогооны өрөө таазны түвшин зөрүү 2 хана засах
- шатны хамгаалалт босоо рек бэхэлгээ сайжруулах, солих
- Шатны хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих бариул, бэхэлгээ сайжруулж тохируулга хийх, мөн хүүхэд барьж гарах боломжийг хангах
- Шалны түвшинг нэг түвшинд байлгах
- Спорт зааланд тоноглол хийж өгөх, сэндвичин хавтанг засах, АСС-ийг засварлаж бүрэн дуусгах, халаах хэрэгсэл хамгаалах
- Галын спектер систем засварлах, ороох
- Урлаг зааланд шал нэг түвшинд болгож тайз хийх, зурагт паркетан шал байна
- Гадна усны хаялга солих, гадна хашааны суурь засах, гадна шот бариул хийх, хашаанд хаалга хийх
- Холбогдох зураг төсөл холбогдох бичиг баримтын нэг хувийг ашиглагчид хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Эрхэс констракшн ХХК-ийн архитектор **В.Сувд-Эрдэнэ**:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний цахилгаан өргөгчийг туршилт хийж, бэхэлгээ төмрийг зохих ёсоор хүчитгэж бэхлэх
- Галын спинклер шугам хоолойг будах
- Галын дохиоллыг зураг төсөлд заагдсан тоо хэмжээгээр төлөвлөх
- Спорт заалны гэрэл болон розетканд хамгаалалт /механик гэмтлээс хамгаалах/ хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Дарцагт ноёд групп ХХК-ийн захирал **Д.Ганзориг**:

- Комиссын гишүүдийн өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлтсийн хяналтын инженер **Х.Орхонсэлэнгэ:**

- Холбооны шалны розетка хийх
- Урлаг заалны зарлан байрлуулах /тоноглолыг ашиглагчтай зөвшилцөн байрлуулах/
- Үүдэнд байгаа бичигч ТӨХ-г рак дотор хийх
- Үүдэнд байгаа тэмдгүүдийг тогтоох

Нийт комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**


- Барилгын норм ба дүрмийн дагуу зохиогч өөрчлөлт бүрийг тусган нэгдсэн дүгнэлтийг нэгтгэн бичих
- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дагуу чанарын баталгаа албан тоот ирүүлэх
- Давхар бүрийн өнгийг тодоор хийсэнд зохиогч, захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч тайлбар ирүүлэх, өнгийг өөрчлөх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх. Үүнд: амрах сандал 6ш, гэрлийн шон 4ш, хогийн сав 3ш, мод бутлаг ургамал 15ш, зүлэгжүүлэлтийн ажил
- Гадна хашааны бетон цутгалт дээрх төмрүүдийг таслах, будах, аюулгүй байдлыг хангуулах
- Усны хаялга, ус зайлуулах системийг хэрхэн төлөвлөсөн тухай хянуулах, стандартын дагуу усны хаялгыг төлөвлөн гүйцэтгэх, уналтыг зөв гаргах, авто зам ус зайлуулах хоолой биш!
- Давхар бүрд явж буй шугам хоолойг зориулалтын материалаар хамгаалах
- 212-ийн 8.1-ийг баримтлах
- Буулгалтын ажлын зөвшөөрлийг хянуулах

Нийт комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд хүлээн авах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянгол дүүргийн 32 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 3 давхар 2 блок, 640 суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газар,
Барилга байгууламжийн
ашиглалт, бүртгэлийн хэлтсийн
даргын үүргийг орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар,
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Танд